

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /жилийн эцэс/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ							
Зорилго 1. Соёл, урлагийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэнэ.							
1.1 Зорилт 1. Стратегийн зорилт 1. Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.							
1.1.1	“Аймгийн соёл, урлагийн салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөр” /2022-2025/ боловсруулж батлуулна.	Үйл ажиллагаа	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрыг байгуулж, Соёлын сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтэц дүрмийг баталсан. Соёлын сайдын 2022 оны 05 дугаар сарын 10 -ны өдрийн Б/13 дугаар тушаалаар Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газрын дарга томилогдож, 05 дугаар сарын 17-ны өдөр ажлаа хүлээн авснаар албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тус аймагт Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Хонгор сумын Соёлын төв, Орхон сумын Соёлын төв, Шарын	80%

						<p>гол сумын Соёлын төв зэрэг соёл, урлагийн чиглэлээр 7 байгууллага үйл ажиллагаа явуулж, нийт 166 соёл, урлагийн ажилтан ажиллаж байна.</p> <p>Аймгийн соёл, урлагийн салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Судалгааны ажил хийгдсэн. Газрын стратеги төлөвлөгөөг батлуулсны дараагаар аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахаар хүлээгдэж байна.</p>	
1.1.2	Аймгийн соёл, урлагийн салбарын Залуучуудын зөвлөл байгуулж үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Үйл ажиллагаа	Байгуулагдсан эсэх Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/57 тушаал	-	1	Дархан-Уул аймгийн соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийг 25 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Соёлын бүтээлч үйлвэрлэлийн 12 салбарын залуучуудын хөгжлийн 14 салбарын төлөөлөл Соёлын сайд Ч.Номинтой уулзалт хийхэд оролцсон. Соёлын салбарын залуучуудын зөвлөл нь 3 удаа 15 хүний бүрэлдэхүүнтэй уулзалт хийж, төлөвлөгөөт ажлуудад салбарын залуучуудын оролцоог ханган ажиллаж байна.	100%
1.1.3	Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулж батална.	Үйл ажиллагаа	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай тушаалыг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/06 дугаар тоотой баталсан. Соёл, урлагийн газрын дарга 2022 оны 11 дүгээр сарын 18-нд урьдчилсан байдлаар ЗГХА-Соёл, урлагийн газар, Соёлын яамны удирдлагын түвшинд танилцуулсан.	90%
1.1.4	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг боловсруулан батална.	Үйл ажиллагаа	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	Соёл, урлагийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны А/20 дугаар тушаалаар батлан мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
1.1.5	Музей номын сангийн цогцолбор барилгад хяналт тавих ажлын хэсэг	ОНТ	Ажлын хэсэг байгуулагдсан эсэх,	-	1	Музей номын сангийн цогцолборын үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын Захирамжаар байгуулагдсан. Улмаар Музей номын сангийн	100%

	байгуулж, Музейн үзэл баримтлалыг боловсруулж батална.		Боловсруулсан баримт бичгийн тоо			<p>цогцолборын үзэл баримтлал боловсруулах ажлын хэсэг байгуулах арга зүйн сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 21- ний өдөр аймгийн ЗДТГ-т зохион байгуулав. Тус сургалтад аймгийн Засаг даргын орлогч, хэлтэс агентлагийн дарга нар хамрагдлаа.</p> <p>Сургалтыг Байгалийн түүхийн музейн сан хөмрөгийн хэлтсийн дарга, доктор Ж.Мяндас, Японы соёлын өвийн гадаад хамтын ажиллагааны консорциумын гишүүн, сэргээн засварлагч, доктор О.Ангарагсүрэн, Монгол улсын Үндэсний номын сангийн ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох хэлтсийн дарга Г.Гүнжинлхам, Соёлын яамны Номын сангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах шинжээч Б.Баяраа, Үндэсний номын сангийн Ерөнхий номын санч Т.Баярлах нар удирдан явуулав. Дээрх эрдэмтэн судлаачдыг ажлын хэсэгт ажиллуулахаар санал авч аймгийн Засаг даргын Захирамжийн төслийг боловсруулсан.</p>	
1.2	Зорилт 2. Стратегийн зорилт 2. Соёлын салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дижитал шилжилтийг хийнэ.						
1.2.1	Салбарын болон байгууллагын статистик мэдээг нэгтгэн боловсруулах үйл ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Статистик мэдээний тоо	Статистик мэдээ 2021 оноор	Мэдээг үнэн бодитой, цаг хугацаанд тайлагнана.	<p>Соёлын 7 байгууллагын 2022 оны үйл ажиллагааны статистик 1.3-УБ, 2.3-М, 3.3-НС, 4.3-СТ, 7.3-СУ-1 маягтаар мэдээ тайланг нэгтгэн аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2022.02.09-ний өдрийн 35 тоот, Хөрөнгө санхүүгийн статистик 6.3-СУХС мэдээг БШУГ-ын даргын 05.09-ний өдрийн 187 тоот, Соёлын сайдын 2021.12.15-ны өдрийн А/300 тоот тушаалын дагуу 2022 оны соёлын байгууллагуудын үйл ажиллагааны статистик тоон мэдээллийг улирал бүрээр тайлагнаж ЗГХА Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.</p>	100%

						2022 оны IV улирлын статистик мэдээг хуулийн хугацаа 2022.12.10-ны өдөр нэгтгэн хүргүүлнэ.	
1.2.2	Аймгийн бүртгэл мэдээллийн сангийн бүртгэлийг чанаржуулах, хяналт шинжилгээ хийнэ.	Үйл ажиллагаа	Хамрагдсан тоо	-	3	Хяналт-шинжилгээ үнэлгээний цахим сан, гүйцэтгэлийн удирдлагын цахим санг ашиглах дадлагажих ажил хийгдэж байна. СУГ болон тус газрын 2 хэлтсийн эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахим программд оруулсан.	100%
1.2.3	Салбарын байгууллагуудад ERP болон ABLE дотоод удирдлагын нэгдсэн системүүдийг нэвтрүүлж хэрэглээг тогмолжуулна. Тоон гарын үсэг нэвтрүүлж, иргэдэд үзүүлж буй зарим үйлчилгээг цахимжуулна.	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн хувиар	-	100%	<p>- Соёл, урлагийн газрын дарга болон харьяа соёлын байгууллагын удирдлагууд, албан хаагчдад тус бүрд нь албаны мэйл нээсэн. Хэрэгжилтийн тайланг Соёлын яаманд 2022 оны 10 дугаар сарын 25-нд цахимаар хүргүүлсэн.</p> <p>- ERP системд Газрын болон харьяа соёлын байгууллагуудын дарга, албан хаагчид бүртгүүлж тус системийг ашиглаж хэвшсэн. Мөн аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн дотоод удирдлагын цогц систем /эйбл/-д Газрын дарга, албан хаагчдыг бүртгэж цаг үеийн мэдээ мэдээллийг авч тус программыг ашиглан хэвшиж байна.</p> <p>- Цахим гарын үсэг хэрэглэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 6 албан хаагч тоон гарын үсэг авсан.</p> <p>- Соёлын байгууллагуудын нэгдсэн портал сайтыг ашиглалтад оруулж буйтай холбогдуулан тус газрын цахим хуудас болох http://da.moc.gov.mn/ -ны ангилал, цэс үүсгэж мэдээлэл оруулах ажлыг сургалтад хамрагдсаны дагуу хийж гүйцэтгэж байна. Тухайлбал: Мэдээ мэдээлэл цэсэд нийт 44 мэдээлэл нийтэлсэн. Мөн Уран бүтээл-1500, Үзвэр үйлчилгээ-189, Соёлын биет бус өв-969,</p>	100%

						<p>Баримтат өв-45 гэх зэрэг танилцуулга мэдээллүүдийг нийтэлсэн.</p> <p>- Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар нэртэй https://www.facebook.com/darkhan.gov/ пэйж хуудсыг хөтлөн ажиллуулж, тус газрын болон соёлын байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй мэдээлж иргэд олон нийтэд сурталчилж байна. Тус цахим хуудсыг 2022.12.01-ний өдрийн байдлаар 23000 хүн дагаж, 19000 хүнд таалагдсан байна.</p> <p>Тус цахим хуудсыг 2022.12.01-ний өдрийн байдлаар 23000 хүн дагаж, 19000 хүнд таалагдсан байна.</p> <p>Соёл, урлагийн газар нь “Цахим Дархан” төслийн хүрээнд нэвтрүүлсэн ersdel-darkhan https://ersdel.e-darkhan.mn/, e-darkhan https://e-darkhan.mn/, иргэдийн индэр цахим системүүдийг ашиглаж байна. 2022 оны 10 дугаар сарын 23, 24, 11 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд Соёл, урлагийн газрын болон харьяа соёлын 7 байгууллагын пэйж хуудас, Дарханы соёлынхон группт байршуулж иргэд, олон нийт, соёлын ажилтнуудад сурталчилсан. Аймгийн Мэдээлэл технологийн албанаас цахим системд нэвтрэх и-мэйл, нууц үгийг авч соёлын байгууллагуудад хүргүүлсэн. Тус системүүдээр дамжуулан Дархан-Уул аймгийн иргэдэд Төрийн байгууллагийн мэдээллийг хүргэх болон өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч байна.</p> <p>Одоогоор тус цахим системүүдэд иргэдээс соёлын чиглэлээр ирсэн санал, гомдол байхгүй байна.</p>	
1.2.4	“Цахим соёл” үйлчилгээг түгээн дэлгэрүүлж, дүрс бичлэгийн студи байгуулна.	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн хувь	-	50%	<p>“Цахим соёл” үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх хүрээнд:</p> <p>- Залуучууд театрт дуу дүрс бичлэгийн студийн байрыг гаргаж бэлтгэсэн. Камер, өнгөт принтер, монтажны компьютерийг өөрсдийн үйл ажиллагааны орлогоор худалдан авсан.</p>	100%

			<p><i>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01-А/132 захирамж</i></p>			<p>Тус студид цахим концерт, шинэ уран бүтээлүүдийн ТВ шторк, контентыг бэлтгэн цахимаар сурталчлан ажиллаж байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - “Нүүдэлчин Монгол” соёлын фестивалийн Мал маллах арга ухаан ай савын төрөлд Орхон сумын 2 дугаар багт нутагладаг Н.Бадарчийг оролцуулж видео контент бэлтгэсэн. - “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийн 2 тв шторк, клип хийлээ. - “Үлгэрийн ертөнц 2” кино контентыг хийж 12 дугаар сарын 06-нд үзэгч хүүхдүүддээ толилуулав. Кино контент нь 12 үлгэртэй үүнээс 10 үлгэр нь Монгол ардын үлгэр, 2 нь Орос ардын үлгэр юм. - “Цахим Музей”-н хүрээнд СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, сурталчлах зорилгоор 18 удаагийн видео, шторк бэлтгэн цахимаар сурталчилав. - Шарын гол сумын Соёлын төв нь Иргэдэд цахим орчны соёлтой хэрэглээг төлөвшүүлэх, хэн нэгэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэх боломжийг олгох зорилгоор “Талархлын орон зай” цахим аян өрнүүлснээс гадна “Номтой-Оюунлаг төрийн албан хаагч”, “Миний омогшил бахархал” цахим илтгэлийн уралдаан, “Шарын голчуудад төлөвшүүлэх соёл” цахим хэлэлцүүлгийг цувралаар зохион байгуулав. - Хонгор сумын Соёлын төвөөс орон нутаг судлах танхим, нийтийн номын сан, хөгжим, бүжгийн спортын мэдлэгийг иргэдэд олгох зорилгоор 7 хоногт 2-оос доошгүй мэдээллийг цахимаар нийтэлж хэвшсэн. 	
--	--	--	--	--	--	--	--

ХОЁР: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Зорилго 2. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

2.1 Зорилт 1. Стратегийн зорилт 3. Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 8. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.

2.1.1	“Соёлын бүтээлч үйлдвэрлэл” нээлттэй өдөрлөг зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Арга хэмжээний тоо	-	1	<p>2022.11.01-30 Соёлын бүтээлч сарын туршид аймгийн хэмжээнд 134 ажлыг зохион байгуулж 69050 хүнд соёл, урлагаар үйлчилсэн.</p> <p align="center"><i>Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.</i></p> <p>“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд: - Соёлын яамнаас зохион байгуулсан "Соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, уламжлалт гар урлалыг дэмжин хөгжүүлэх боломж шийдэл - 2022 нэгдсэн арга хэмжээнд 1000 гаруй урлаачдын 2000 бүтээл оролцсоноос Дархан-Уул аймгийн оролцогч “Цайны их зам” ХХК-ийн үйлдвэрлэдэг ширэн эмээлүүд “Шилдгийн шилдэг” бүтээгдэхүүнээр шалгарлаа. - Аймгийн Төв номын сангаас "Монгол бахархал" хөөрөг, даалин урлаач, уран дархчууд, уран хатгамалчдын сургалт, үзэсгэлэн худалдааг Эмэгтэйчүүдийн ордон, Дархан сумын Ахмадын хороотой хамтран зохион байгуулж 100 гаруй иргэд хамрагдсан. - Дарханы Зураач, урчуудын эвлэлээс 28 уран бүтээлчийн 54 бүтээлээр "Шинэ салхи" уран бүтээлийн үзэсгэлэнг Дархан, Орхон суманд 7 хоногийн турш толилуулж 500 гаруй хүн үзэж сонирхсон. - Аймгийн Музейд МУСТА, уран дархан Д.Түмэнжаргал, Н.Мөнгөнбаяр, С.Мөнхбаатар нарын ур ухаанаар бүтээсэн 40 орчим орчин цагийн соёлын өвийн бүтээлүүд дэлгэсэн. Мөн үеэр МУСТА, уран дархан Д.Түмэнжаргал</p>	100%
-------	--	---------------	--------------------	---	---	--	------

						<p>"Уран дарханы түүхэн хөгжил" сэдвээр ярилцлага хийлээ. Нэг өдөр дэлгэсэн түр үзэсгэлэнг 58 хүүхэд, 28 насанд хүрэгч нийт 86 хүн үзэж сонирхлоо.</p> <p>- Тус соёлын төвөөс Шарын голчууддаа эко даавуун тор хэрэглэхийг уриалан "Нутгийн брэнд тор"-ыг худалдаанд гаргалаа. Мөн бүтээлч үйлдвэрлэгчдээ дэмжиж цахим контент бэлтгэн 37462 хүнд сурталчилав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хусны нүүрс үйлдвэрлэгч "Домогт Шарын гол" ХХК • Дээл урлалын "Өлзий хээ" оёдол эрхлэгчид • Эсгий гар урлалын үйлдвэрлэл явуулдаг иргэд • Гэрийн нөхцөлд уламжлалт аргаар хэрчсэн гурил үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг танилцуулав. <p>- Хонгор сумын Соёлын төвөөс 2022 оны 11 дүгээр сард "Бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа"-г сумын ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа. Нийт 150 орчим иргэн үйлчлүүлсэн.</p>	
2.1.2	Салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж батална.	Үйл ажиллагаа	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	<p>Соёлын байгууллагууд тус бүр хөгжлийн хөтөлбөр батлан ажиллаж байна. Тухайлбал: Хүүхдийн номын ордны сургалтын хөтөлбөр нь албан хаагч нэг бүрийг ажлын байранд нь сургах, өөр байгууллага, хамт олноос суралцах буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах, боловсролын мэргэжлийн байгууллагад суралцуулах, тодорхой сэдэв эсвэл мэргэжлээрээ дагнан суралцах гэсэн 4 зарчимд тулгуурлан зохион байгуулдаг. Тус 4 зорилтын хүрээнд 31 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 189 ажилтан, албан хаагч буюу 94.1% нь хамрагдсан.</p>	100%

						<p>- ТАЗ-ийн салбар зөвлөлөөс 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр аймгийн СУГазарт хүний нөөцийн хяналт, шалгалт хийсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг тайлагнасан.</p> <p>- ТАЗ-ийн 08 дугаар сарын 31-ний өдрийн 535 дугаар тогтоолоор Соёл, урлагийн газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт батлагдснаар ТАЗ-ийн салбар зөвлөлд тусгай шалгалт зарлах сул орон тооны захиалгыг хүргүүлсэн. Тусгай шалгалтаар 5 албан хаагч тэнцэж ТАЗ-ийн салбар зөвлөлийн 85, 86, 88, 89, 90 дүгээр тогтоолын дагуу тус албан хаагчдыг Соёл, урлагийн газрын даргын тушаал гарч томилсон. 12 дугаар 10-ны өдрийн байдлаар дарга, 6 ажилтан нийт 7 албан хаагч ажиллаж байна.</p> <p>- Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 65 дугаар зүйлийн 65.6 "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг баримтлан ажиллаж байна. Энэ дагуу хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан тухай тайланг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 112 дугаар тоот албан бичгээр ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлсэн.</p>	
2.1.3	Албан хаагчдыг төлөвлөгөөт болон чадавхжуулах сургалтад үе шаттайгаар хамруулна.	Үйл ажиллагаа	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	11	2022 оны 12 дугаар сарын байдлаар соёлын салбарын нийт 166 ажилтан албан хаагчдаас танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 142 хүн хамрагдсан нь нийт ажиллагсадын 85.5% байна. Тухайлбал: 20 удаагийн цахим сургалтаар 90 хүн, 54.2%-тай хамрагдаж 11 удаагийн танхимын сургалтаар 52 хүн, 31.3%-тай хамрагдаж Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад нийт 30 удаагийн сургалтад 2 хүн, 1.2%-тай тус тус хамрагдсан байна. Нийт танхим болон цахим	100%

						сургалтад 142 хүн буюу 85,5%-тай хамрагдсан үзүүлэлттэй байна. Сургалтын дэлгэрэнгүйг хавсаргав.	
2.1.4	Албан хаагчдад эрүүл зөв, амьдрах, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	11	- "Илүүдэл жингүй - Эртэч Монгол" аян 2022.02.16 - 06.01-ний хугацаанд үргэлжилсэн. Тус аянд соёлын салбарын 7 байгууллагын 160 гаруй ажилтнууд манлайлан оролцсон. - Миигii dance school бүжгийн клубтэй хамтран 1 сарын бүжгийн хөдөлгөөнөөр эрүүлжих "Эрүүл эртэч Монгол" аяныг долоо хоног бүрийн 1, 3, 5 дахь өдрүүдэд өглөө 06:00 цагт нийт 12 удаа зохион байгуулсан. - Нийт ажилтнууд "Халдварт бус өвчин, эрүүл зөв зохистой хооллолт", "Идэвхтэй хөдөлгөөний ач тус" сургалт, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 60%-тай хамрагдсан.	100%
2.2	Зорилт 2.Стратегийн зорилт 6. Үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ. Стратеги 9. Соёлын бодлого ба үйл ажиллагааг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд идэвхжүүлж, олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ. АЗДҮАХ: 1.6.1. Соёл, урлагийн байгууллагын хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.						
2.2.1	Төв номын сангийн хэмрөгийг нэмэгдүүлнэ.	5.0 сая ОНТ	Нэмэгдсэн сан хөмрөгийн тоо Соёлын тухай хуулийн 16.2.3, 16.2.5, 18.1, 18.6, Номын сангийн тухай хуулийн 16.2.5, 23.1, 23.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 124 дүгээр зарлиг; (Үндэсний баялагт ном хандивлах тухай), Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	225 боть	500 боть	- 2022 оны 12 сарын байдлаар Улсын төсөв болон хандиваар 34,255,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар номын баяжилт хийж, сан хөмрөгийн тоо 3037 ботиор нэмэгдсэн. Үүнээс: Хандиваар 7,614,490 сая төгрөгийн 1211 нэр төрлийн 1318 боть, худалдаагаар 26,641,099 сая төгрөгийн 661 нэр төрлийн 1720 боть ном, 10 нэр төрлийн тогтмол хэвлэл, урьд оны үлдэгдэл 83 нэр төрлийн 125 боть ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр фондоо баяжуулсан. 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 72 945 боть номтой. Үүнээс 70704 нь цахим каталогт байршсан. Үүнд: Хүүхдийн Номын Ордны номын сангийн цахим каталогт http://darkhan.monbiblio.com 15,000 гаруй боть	100%

						<p>ном, Төв номын сангийн сан хөмрөг нь 57945 боть номтой, үүнээс 55704 номыг электрон каталогт http://darkhan.lib4u.net оруулсан.</p> <p>Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд: Найрамдлын Дархан сонины 1983, 1984, 1985, 1986, 1988 оны 426 дугаар 1737 хуудас 6922 талыг цахим сүлжээнд орууллаа.</p> <p>- 12 дугаар сарын 02-ны байдлаар Уншигч 10,919, Ирэгсэд давтагдсан тоогоор 101,881, Ном олголт 131,006 боть номоор үйлчилсэн байна.</p> <p>- 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 823 уншигчдад 3,727 боть номыг гэрээр олгож үйлчилсэн.</p> <p>- Нүүдэл, зөөврийн номын үйлчилгээг 23 удаа 1037 хүнд 1360 боть ном олгож үйлчиллээ.</p>	
2.2.2	“Дарханы нэвтэрхий толь” ном бүтээх судалгааны ажлыг эхлүүлнэ.	Үйл ажиллагаа	<p>Хэрэгжилтийн хувиар</p> <p>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p>	20%	80%	<p>Дархан хотын уугуул иргэд болон тус хотын бүтээн хотын бүтээн байгуулалтад оролцож явсан 120 гаруй ахмадуудтай уулзаж 1000 гаруй гэрэл зураг, товч намтар, дурсамж судалгааны материал цуглуулаад байна. Номын эх бэлтгэлийн 90 гаруй хувьтай. Ерөнхий редактораар Я.Зэнээмэдэр(Ph.D.) проф. ажиллаж байна. Энэ хүрээнд Дархан, Хонгор, Шарын гол сумдын түүх соёлын дурсгалт газруудтай танилцах аялалыг 2022.11.23-нд зохион байгуулав. Тус аялалаар орон нутгийн тахилгат хайрхан уулсын зургуудыг авч баримтжуулав</p>	90%
						<p>- Соёлын яамны санхүүжилтээр аймгийн Музей нь 29 уран бүтээлчийн намтар, 62 урлагийн бүтээлийн тайлбар, мэдээлэл болон гэрэл зургаас бүрдсэн сургалт сурталчилгааны “Дархан Музейн Урлагийн бүтээлүүд” номын эхийг бэлтгэж, хэвлүүллээ. Номын</p>	Нэмэлт ажил хийсэн.

						нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хийв.	
2.2.3	Театр, урлагийн уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Уран бүтээлийн тоо Соёлын тухай хуулийн 22.1.6, 22.1.7, Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 61 дүгээр тогтоол, “Оюунлаг Дарханчууд-2” дэд хөтөлбөрийн хүрээнд	1	2	<p>Аймгийн хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 104737 хүн амын 69.9% буюу давхардсан тоогоор 72373 насанд хүрэгчдэд, 1-19 насны нийт 38021 хүүхдийн 58,2 %-д буюу давхардсан тоогоор 22134 хүүхдэд театр, урлагийн уран бүтээлээр үйлчилсэн байна. Нийт үзэгчид давхардсан тоогоор 96095 байна.</p> <p>Гадна, дотны тоглолтыг дэмжин ажиллах, соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 292 удаагийн гадна, дотны тоглолт, арга хэмжээ зохион байгуулагдсан байна.</p> <p>Залуучууд театр нь тайлант онд дотоодын 21 уран бүтээлийг 103 удаа тоглож 36386 хүнд үзүүлсэн. Тухайлбал:</p> <p>Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Ногоон Дархан 2032 хөтөлбөрийн хүрээнд “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийг 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр нээлтээ хийж, одоогоор 30 удаа 9419 хүүхэд багачуудад хүргэсэн.</p> <p>Өвөл цагийн үзвэрийн нээлт, Лев. Корсунскийн зохиол “Нэр зээлдэгч” драмын жүжиг 2022 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр нээлтээ хийж одоогийн байдлаар 7 удаа тоглогдож 2239 үзэгчдэд хүргэсэн гэх мэт.</p> <p>Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.</p>	100%
2.2.4	Музейн үзмэрт байгаа мөнгөн тэмдэгтүүдийг иж бүрдэл ажлын хүрээнд сан хөмрөгөө баяжуулна.	Үйл ажиллагаа	3,250,000	-	14	Аймгийн Музейд орон нутгийн 3,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 монгол мөнгөн тэмдэгтийг иж бүрдэл болгон бүрдүүлсэн. Ингэснээр монгол мөнгөн тэмдэгтийг сурталчилан таниулах үзмэр баяжилт нэмэгдсэн.	100%

						<p>Үзвэрийн 4 танхимд нийт үзмэрийн тоо 969 дэсийн 1362 ширхэг үзмэртэй байсан бол 2022 онд 29 дэсийн 46 ширхэг үзмэрээр шинээр баяжуулж 998 дэсийн 1408 ширхэг болж нэмэгдсэн.</p>	
2.3	Зорилт 3. Стратегийн зорилт 3. Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээг боловсруулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.						
2.3.1	<p>“Домог амилсан нутаг” дуулалт жүжиг эвэнт</p>	<p>Үйл ажиллагаа</p>	<p>Тоглогдсон тоо</p>	<p>10</p>	<p>14</p>	<p>Соёлын тухай хуулийн 22.1.6, 22.1.7-д заасны дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын яам, Дархан-Уул аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр Дархан хотын 60 жилийн түүхт ойд зориулсан “Домог амилсан нутаг” дуулалт жүжиг эхний хагас жилд 2022 оны 04 дүгээр сарын 12, 13, 14, 15, 16, 23, 25, 27-ны өдрүүдэд нийт 18 удаа тоглож, 5860 хүнд үйлчилсэн. Нийт 23 сая төгрөг төвлөрүүлсэн.</p> <p>Тус уран бүтээлээр Гэгээн муза 16 Олон Улсын театрын наадамд нэр дэвшин оролцсон.</p>	<p>100%</p>
2.3.2	<p>Сумдын соёлын төвийн үзвэр үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийг соён гэгээрүүлэх ажиллагааг идэвхжүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагаа</p>	<p>Хэрэгжилтийн хувиар</p>	<p>-</p>	<p>100%</p>	<p>Орхон, Хонгор, Шарын гол сумын Соёлын төвүүдэд нийт 61 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулагдаж 11614 том хүн, 3374 хүүхдэд соёл, олон нийтийн үйл ажиллагааг хүргэсэн байна. Энэ нь нийт сумдын хүн амын 67%-д хүрч ажилласан байна.</p> <p>Соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Дархан хот дахь “Оргил”, “Номин” худалдааны төвүүдэд очиж хөгжмийн бүтээлээр үйлчиллээ.</p> <p>Хөдөөгийн 3 сумдад “Алтан намар “ аялан тоглолтыг амжилттай зохион байгуулж нийт 800 гаруй ард иргэдэд соёл урлагийн арга хэмжээгээр үйлчиллээ.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хүүхдийн хүчирхийллийн эсрэг болон архи,</p>	<p>100%</p>

						согтууруулах ундааны хор уршгийг хүүхэд залууст сурталчлан таниулах соён гэгээрүүлэх зорилготой Тоонот рекордс уран бүтээлийн нэгдлийн “Тоонот 21*21” тоглолтыг 2022 оны 06 дугаар сарын 20-нд зохион байгууллаа.	
2.3.3	Төрийн албан хаагчдын Урлагийн их наадам зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Арга хэмжээний чанар, үр дүн Хэрэгжилтийн хувиар	-	100%	“Авъяаслаг төрийн албан хаагчид” урлагийн наадмыг 2022 оны 11 дүгээр сарын 11, 12, 18, 19-ний өдрүүдэд Гоцлол, дуэт, хамтлаг дуу, гоцлол, хамтлаг бүжиг, гоцлол, хамтлаг хөгжим, язгуур урлаг, уран уншлага, жүжигчилсэн тоглолт зэрэг 10 төрлөөр зохион байгуулж нийт 25 байгууллага 12 багт хуваагдан амжилттай оролцсон. Төрөл тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж урамшуулсан. Шилдэг номеруудаар 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гала тоглолт тоглосон.	100%
2.3.4	Дэлхийн болон Үндэсний номын баяр, Дэлхийн Хүүхдийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр, Зохиолч уншигчдын уулзалт, шинэ номын сурталчилгаа зэрэг соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.	10 сая УТХО	-Хамрагдсан иргэдийн тоо, Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувиар Номын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.3.5, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг (Номын баярын өдөр тэмдэглэх тухай)-ийг хэрэгжүүлэх хүрээнд	500 хүн 3 ажил	1000 хүн 3 ажил	“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2022”-ыг УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор “Илүү их уншъя” уриатайгаар 2 удаа зохион байгууллаа. Тус өдрүүдэд нийт 70 удаагийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 26 байгууллага, 19605 хүн оролцсон. Тухайлбал: Төв номын сан, Музей, Залуучууд театр, Хүүхдийн номын ордон, бүх шатны боловсролын байгууллагууд, иргэд, уншигч олны дунд хүртээмжтэй байдлаар явуулж нийт 15 байгууллагын 130 гаруй ажилтан, СӨБ-ын байгууллагын 160 орчим хүүхэд, ЕБС-ийн 170 гаруй сурагч, их дээд сургуулийн 80 оюутан, 18 багийн ахмадын зөвлөлийн 280 гаруй ахмадууд, “Номын соёлт ертөнц” ТББ-ын хамт олон, Улаанбаатар хотоос 50 зохиолчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирж номын баярт оролцлоо. Энэ хүрээнд: - Хэвлэлийн бага хурал 2 - Эрдэм шинжилгээний хурал 2 удаа 94 хүн - Зохиолч, уншигчдын уулзалт 10 удаа 811 хүн - Уншаад урагшлахуй	100%

					<p>- Оюунлаг Дархан өдөрлөг 5 удаа 497 хүнд 437 боть ном</p> <p>- Номын үзэсгэлэн 18 баг, 2 байгууллагад 610 боть ном</p> <p>- Номын сангийн тухай хуулийн хэлэлцүүлэг 1 удаа 15 хүн</p> <p>- Номын худалдаа 18 баг, 2 ААН</p> <p>- шинэ номын нээлт 4 удаа 191 хүнд</p> <p>-Кофе ба цай уншлага 1 удаа 20</p> <p>- Уран зохиолын дүрийн болон уншигчдын жагсаал 1 удаа 300 гаруй хүн</p> <p>- Өв соёл, язгуур урлаг сурталчлах ажил 1 удаа 120 хүн</p> <p>- Ургаа уудалъя угийн бичгийн үзэсгэлэн 1 удаа 60 гаруй хүн</p> <p>- Уралдаан 6 удаа 250 хүн</p> <p>-лекц 9 сэдвээр 140 хүн</p> <p>-Илтгэл 1</p> <p>Хямдралтай номын худалдаа</p> <p>- “Непко” хэвлэлийн газраас зохион байгуулсан “Кодоо бичиж сурцгаая” уриатай Код гэж юу болох, анимейшн бүтээж сурах сургалтад 15 хүүхэд хамрагдаж анхан шатны мэдэгдэхүүнтэй боллоо.</p> <p>- Соёлын яамнаас “Үндэсний бичиг үсгийн баяр 2022” хаврын баярыг “Үндэсний бичиг үсэг - Монгол соёлын үнэт өв” уриан дор зохион байгуулж тус баяраар 21 аймгийн Нийтийн номын сангуудаас шилдэг номын санг шалгаруулж “НОМ ЦОМ”-ыг Дархан-Уул аймгийн Төв номын санд гардуулан өгөв.</p> <p>“Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ЕБС-ийн 3 анги хамт олныг тодруулж шагнав.</p> <p>- Шинэ болон фондод байгаа номыг сурталчилан, цахим болон танхимаар үзэсгэлэн гаргалаа. Тухайлбал: “Шинэ номын үзэсгэлэн” 16 удаа 411 боть номоор,</p>	
--	--	--	--	--	---	--

Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1.3, Номын сангийн тухай хуулийн 14-р зүйл

			14.3.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд			<p>“Сэдэвчилсэн номын үзэсгэлэн”-г 52 удаа 3038 боть номоор 8309 хүнд хүрсэн. “Номын цахим үзэсгэлэн”-г 6 удаа 135 боть номоор гаргасан. /Цахим үзэсгэлэнгийн хандалт- 3811/</p> <p>- Чанга уншлага 59 анги бүлгийн 2195 хүүхдэд хийсэн.</p> <p>Ард иргэдийг номтой нөхөрлүүлэх аяны хүрээнд:</p> <p>-“Үдшийн Уншлага”, “Зуны уншлага” –ыг “Найрамдал талбайд”, “Дархан-50” цогцолборт 7 удаа зохион байгуулж, шинээр 27 уншигч бүртгэж, 388 ирэгсдэд 378 боть номоор үйлчилсэн.</p> <p>- “Номтой аялал”-ыг 5 удаа зохион байгуулж 176 сурагч хамрагдсан.</p> <p>- “Соёлын орон зай” нээлттэй өдөрлөгийн хүрээнд:</p> <p>-“Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан 3 сурагчийг тодруулж шагнав.</p> <p>- Дархан-Уул аймгийн зохиолчдын номын үзэсгэлэн</p> <p>-Шинэ номын үзэсгэлэн 183 боть ном</p> <p>- Хуучин номын худалдаа</p> <p>-“Угсаатны зүйн үзмэр”-үүд гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан нийт 100 гаруй хүүхэд хамрагдсан.</p>	
2.3.5	“Хос бичигтэн байгууллага болох” аяныг өрнүүлж, үр дүнг олон нийтэд сурталчилна.	Үйл ажиллагаа	<p>Байгууллагын тоо</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо</p> <p>Соёлын тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.2, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралт; “Монгол</p>	6	12	<p>- “Хос бичигтэн байгууллага” аянд Соёл урлагийн 7 байгууллагыг бүрэн хамруулж ажилласан.</p> <p>- “Бийрээ нийлье” уран бичлэгийн уралдааныг зохион байгуулж 5 сургуулийн 29 сурагч, 3 багш оролцлоо.</p> <p>- 2022 оны 10 дугаар сарын 16-нд “Хамгийн сайхан хот” монгол бичгийн үзэсгэлэн болж нийт 600 хүн хамрагдлаа.</p> <p>- “Монгол бичиг - Монгол бахархал” түргэн уншлагын уралдааныг ЕБС-ийн дунд ангийн</p>	80%

			<p>бичгийн үндэсний хөтөлбөр III", Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 61 дүгээр тогтоол, "Оюунлаг Дарханчууд-2" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд</p>			<p>сурагчдын дунд зохион байгуулж 8 сургуулийн 88 сурагч оролцсноос 18 дугаар сургуулийн есдүгээр ангийн Б.Анударь тэргүүлэв.</p> <p>-Хэлний Бодлогын Үндэсний Салбар Зөвлөлийн Дархан салбартай хамтран "Мөнх оршихуй-III" бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулж багш сурагчдын 42 бүтээлээр үзэсгэлэн гаргав.</p> <p>- "Үндэсний бичиг манай хамт олны өв соёл" цахим контент бүтээх уралдаанд төрийн 30 байгууллага оролцсон бөгөөд үүнээс соёл, урлагийн 2 байгууллагын 32 ажилтан оролцов.</p>	
2.3.6	Угийн бичгийг хөтлөх, сургалтыг иргэдэд зохион байгуулна.	Үйл ажиллагаа	<p>Сургалтын тоо</p> <p>Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.4, 15 дугаар зүйл 15.2.2, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол, Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 61 дүгээр тогтоол, "Оюунлаг Дарханчууд-2" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор</p>	2 удаа	4 удаа	<p>Угийн бичиг хөтлөх нийт 4 удаагийн сургалт зохион байгуулж 34 насанд хүрэгч, 198 хүүхдийг хамруулсан. Үүнд:</p> <p>- "Угийн бичгээ хөтөлцгөө" сургагч багш бэлтгэх сургалтыг Соёл, урлагийн газар, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Ахмадын хөгжлийн төв хамтран 2022 оны 10 дугаар сарын 20, 21-нд зохион байгуулав. 2 удаагийн сургалтад 4 сумын төлөөлөл, соёлын байгууллагын ажилтнууд болон угийн бичиг бичиж сурах хүсэлтэй 23 иргэн хамрагдлаа.</p> <p>- Төв номын сангаас Од цогцолбор сургуулийн 7 дугаар ангийн 12 сурагчид "Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол" сэдвээр сургалт явуулсан. Мөн Хонгор сумын "Нээлттэй хаалга"-ны өдрөөр "Ургаа удалъя" сэдвээр нутгийн 160 гаруй иргэнд сургалт хийсэн.</p> <p>- "Ургаа удалъя" угийн бичгийн үзэсгэлэнг Дархан сумын Ахмадын хороотой хамтран зохион байгуулсан бөгөөд Дархан сумын 18 багийн 14 ахмад угийн бичгийн ном товхимол, гар бичмэлээр оролцсон. Үзэсгэлэнд ирсэн угийн бичгүүдээс 3 угийн бичгийг шалгаруулж өв соёл, удам угсаагаа үр хойчдоо таниулж буйд талархан урамшууллаа. Үүнд: Дархан сумын 3 дугаар багийн иргэн Я.Энэбишийн гэр бүл нөхрийн талын "Өнө мөнхөд бадрах угийн</p>	<p>Танхим болон цахимаар зохион байгуулав</p> <p>100%</p>

						бичиг” 7 үе, эхнэрийн талын “Баян авгынхан удмын шастир” 9 үеэрээ гаргасан ном, Дархан сумын 7 дугаар багийн иргэн Д.Мягмар 9 үеийг оролцуулсан номонд 1800 гаруй удмынхан оролцсон угийн бичиг, 15 дугаар багийн иргэн Хуягбаатарын гэр бүлийн “Чандманийхны удам ургийн хэлхээ” угийн бичгүүд шалгарлаа. - Хүүхдийн номын ордон нь Угийн бичиг хэрхэн хөтлөх талаар 3 цахим мэдээлэл бэлтгэн байршуулж 17899 хэрэглэгчдэд хүргэсэн.	
2.3.7	“Хотын соёл” цуврал аяныг өрнүүлж, үр дүнг олон нийтэд сурталчилна.	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны чанар үр дүн, Хэрэгжилтийн хувиар	-	100%	“Хотын соёл биднээс эхэлнэ” аяныг зохион байгуулав. Нийт 1746 иргэдэд сурталчилсан. Хонгор сумын Соёлын төв, ЗДТГ хамтран хотын соёлыг төлөвшүүлэх хүрээнд “Нөлөөллөөс дээгүүрт” арга хэмжээг зохион байгуулсан. 170 залуус хамрагдсан.	100%

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Зорилго 1. Соёлын өвийг бүртгэх, эрэн сурвалжлах, хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчилна.

3.1 Зорилт 1. Стратегийн зорилт 3. Соёлын өвийг хамгаалж, бүс нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.

3.1.1	Баримтат өвийн эзэмшигчийн бүртгэл судалгааг хийнэ.	Үйл ажиллагаа	Баримтат өвийн тоо Соёлын сайд, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан "Иргэд, сүм хийдэд хадгалагдаж буй баримтат өвийг бүртгэлд хамруулах" ажлын хүрээнд	32	38	Дархан сумын СББӨ-ийг өвлөн уламжлагч О.Туул, Хонгор сумын иргэн СББӨ-ийг өвлөн уламжлагч Д.Бовийшийрэв, Шарын гол сумын Гэлэгпэлжээлийн хийд, Дархан сумын иргэн, марк цуглуулагч Д.Сайнхүү нарт хадгалагдаж байсан нийт 45 ширхэг баримтат өвийг бүртгэн баримтжууллаа. Уг бүртгэлд 1911-1925 оны үеийн засаг захиргаа, шүүх яамны холбогдолтой дүрэм, өргөх бичиг, тогтоол, Дотоод хэргийн яамны офицеруудын гэрэл зураг, Утга зохиол сонины анхны дугаар, Ламын гэгээний хийдийн маарамба Цэдэнбалжираас үе уламжлан ирсэн ном судар, модон бар, танка зураг, Д.Сүхбаатарын марк /1932 онд хэвлэгдсэн/, Атилла хааны	100%
-------	---	---------------	---	----	----	---	------

						марк /1952/, Чингис хааны марк /1962/ зэрэг баримтат өвүүдийг хамрууллаа.	
3.1.2	Биет бус өвийг өвлөн уламжлагч, түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг зохион байгуулна.	3 сая ОНТ	<p>Биет бус өвийг өвлөн уламжлагч, түүх соёлын дурсгалын тоо</p> <p>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, ЗГХА- Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/12 тушаалын 3 дугаар хавсралт</p>	Биет бус өвийг өвлөн уламжлагч 80,	<p>Биет бус өвийг өвлөн уламжлагч - 74, Аймаг нийслэлийн хамгаалалта д байдаг түүх соёлын дурсгалын тоо - 8</p>	<p>Дархан-Уул аймагт “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого”-ын ажлыг Соёл Урлагийн Газар, Музей хамтран 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхэлж бүртгэн баримтжуулалт, судалгааны ажлыг 09 дүгээр сарын 28-нд дуусч тооллогыг www.rich.mongoluv.mn программд дурсгалуудыг шивсэнийг хянаж 100 хувийн гүйцэтгэлтэйгээр дуусгаж Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлж хянууллаа. Тооллогоор нийт 51 дэсийн 361 үзмэрийг 100% хамрууллаа. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн улсын тооллого зохион байгуулах ажилд ЗГХА- СУГ-аас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01-А/299 тоот Захирамж гарч судалгааны ажлыг 11 дүгээр сарын 02-ны өдөр эхлүүлээ.</p> <p>rich.mongoluv.mn программд тус аймгийн 74 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулсан байдаг. Дээрх судалгааны дүнд нийт 90 өвлөн уламжлагчийг бүртгэлд хамруулав. Соёлын биет бус өвийг уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын дагуу судалгааны ажлыг явуулав.</p>	100%
3.1.3	Зөөвөрлөх болон тээвэрлэх боломжгүй уран баримлуудыг сэргээн засварлана.	3.5 сая	Сэргээн засварласан уран баримлын тоо	-	18 баримал	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйл. Соёлын өвийг сэргээн засварлах үйл ажиллагаа 47.1, 47.1.1, 47.1.2 зүйлийг үндэслэн Түүх, соёлын хөдлөх дурсгал болох уран баримал сэргээн засварлах ажлыг аймгийн Музей Дархан-Уул аймгийн Засаг	100%

						даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ажлын хүрээнд 3,500,000 төгрөгөөр хийж гүйцэтгэв. Нийт 18 баримлыг сэргээн засварласан.	
3.1.4	“Илгээлтийн эзэд” буланг тохижуулж, үзвэр баяжуулалтыг нэмэгдүүлнэ.	5.3 сая ОНХС	Хэрэгжилтийн хувиар	-	100%	Соёлын өвийн тухай хуулийн 35 дугаар зүйл Соёлын биет өвийг худалдах, худалдан авах 35.2 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Музейд 1961-1981 онд илгээлтээр Дархан хотод ирж ажиллаж амьдарч байсан айл өрхийн тухайн үеийн байдлыг харуулах зорилгоор “Илгээлтийн эзэд” булан төслийг Дархан сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 5,360,000 төгрөгөөр хийж гүйцэтгэв.	100%
3.1.5	“Нүүдэлчин Монгол” Соёлын биет бус өвийн наадмын I шатны шалгаруулалтыг зохион байгуулна.	ОНТ 21.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувиар Соёлын өвийг хамгаалах тухай хууль, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өв /СББӨ/-ийг хамгаалах тухай 2003 оны Конвенци, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, йн дагуу Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх, судалж сурталчилах, долоон ай савын хүрээнд Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг тодруулж алдаршуулах, орон нутгийн соёлын өвийн бүртгэл	-	100%	Тус аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Захирамжаар “ Нүүдэлчин Монгол ” наадам зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлав. Улмаар 7 дугаар сарын 10-ний өдөр Дархан суманд “Нүүдэлчин Монгол” наадмын 1 дүгээр шалгаруулалтыг 7 ай саваар 100 гаруй иргэнийг оролцуулан зохион байгуулсан. Тус наадмаас 39 өвлөн уламжлагчийг 2 дугаар шатанд шалгаруулав. Тус наадамд аймгийн ЗДТГ-аас 3.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Улмаар “ Нүүдэлчин Монгол 2022 ” соёлын фестивальд бага насны өвлөн уламжлагч 6 хүүхэд, Монгол Улсын Соёлын тэргүүний 9 ажилтан, зургаан Ардын авьяастан зэрэг нийт 61 хүний бүрэлдэхүүнтэй оролцсоноос: -Соёлын бүтээлч үйлдвэрлэл нэвтрүүлсэн төрөлд “Монгол бичиг QR код” бүтээлээр Б.Булганчимэг, -Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” төрөлд Ж.Эрхэмсайхан, - “Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл” төрөлд Ц.Буянхишиг нар шалгарч шилдэг өвлөн уламжлагч медаль тус бүр 1.000.000 төгрөгөөр шагнуулсан. Тус	100%

			мэдээллийн нэгдсэн санг баяжуулах зорилгоор		<p>наадамд оролцоход аймгийн ЗДТГ-аас 5.0 сая, Дархан сумын ЗДТГ-аас 5.0 сая, Хонгор, Орхон, Шарын гол сумын ЗДТГ, Соёлын төвөөс тус бүр 3.0 сая нийт 19 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- "Нүүдэлчин Монгол" соёлын фестивалийн Шилдэг өвлөн уламжлагчдын бүтээл болон "Монгол хүний өв соёл" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг Дарханчууддаа дэлгэн толилууллаа.</p> <p>- Дархан-Уул аймгийн Ахмадын дунд "Өвлөн уламжлагчдын наадам"-ыг 2022 оны 11 дүгээр сарын 10 - 2022 оны 11 дүгээр сарын 30-ны хооронд аймгийн Ахмадын хөгжлийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулав. Тус наадамд аймгийн СУГ-аас шүүгчдийн зардалд 200.000 төгрөг зарцуулсан.</p> <p>- 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Монголын Хүүхдийн Ардын Урлагийн Төв сантай хамтран "Ардын аялгуу" урлагийн их наадмыг СББӨ-ийн өвлөн уламжлагчдын дунд зохион байгууллаа. Тус наадамд гоцлол морин хуур хөгжмөөр Б.Дүйнхэрсүрэн, Хотгойд ардын уртын дуугаар Ш.Наранцэцэг нар Гран при шагналын эзэн боллоо. СББӨ-ийн өвлөн уламжлагч Б.Жавзанжав хулсан хуураар алт, Б.Содовдорж "Шалцат баахан шарга" дуугаар алт, Б.Таамж Хотон бий биелгээгээр мөнгө, Ш.Амгалан Урианхай бий биелгээгээр мөнгө, Б.Баярмаа гоцлол бүжгээр мөнгө, Б.Дарханням ерөөл магтаал, уриа дуудлагаар алт, Л.Лхагваа шанз хөгжмөөр алт, Д.Бямбажав "Самарын 3 толгой" ардын дуугаар мөнгө, Б.Золжаргал "Хулан хонгор" дуугаар хүрэл, С.Одонцоо бий биелгээгээр өргөмжлөл, М.Ариунчимэг гоцлол бүжгээр мөнгөн медалыг тус тус хүртлээ. Шүүгчийн</p>
--	--	--	---	--	---

						бүрэлдэхүүнээр МУАЖ Ө.Баярмагнай, СГЗ Ж.Эрдэнэтуяа, соёл судлаач, МУСТА Г.Нарангэрэл нар ажиллалаа.	
3.1.6	Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хаяг тэмдэглэгээ, хашаажуулах ажлыг эхлүүлнэ.	Үйл ажиллагаа	Хамгаалагдсан үл хөдлөх дурсгалуудын тоо	-	2	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйл, 42.2 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тус аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн бүрэн эрхийн ээлжит бус 13 дугаар Хуралдаанаар /2022.11.23/ Хонгор сумын нутаг Говил уулын орчмын 20 га талбайг “Орон нутгийн хамгаалалтад авах тухай асуудал”-ыг хэлэлцэж орон нутгийн хамгаалалтад авлаа. Уг дурсгалт газрыг Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн Профессорын 2 дугаар багийн ахлагч, доктор Т.Идэрхангайгаар ахлуулсан судалгааны баг 2022 оны малтлагын ажлаар 11 бунхант булш, 3 жирийн иргэний булш, 1 тахилгын байгууламжийг илрүүлсэн юм. 2023 онд дээрх судалгааны баг 3 сарын хугацаатай дахин малтлага хийхээр төлөвлөгөө гаргаж уг ажлын төсвийг Дархан-Уул аймгийн Орон нутгийн төсвөөс 70 сая төгрөгөөр дэмжихээр аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн бүрэн эрхийн ээлжит бус 14 дүгээр Хуралдаанаар батлав. Судалгааг хавсаргав.	100%
Зорилго 2. Соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.							
3.2	Зорилт 1. Стратегийн зорилт 7. Олон улсын стандарт, шаардлагад нийцсэн соёлын барилга байгууламжийг ашиглалтад оруулж, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.						
3.2.1	Музей, Номын сангийн цогцолборын барилга угсралтын ажлын явцыг эрчимжүүлнэ.	2.4 тэрбум УТХО	Ажлын гүйцэтгэлээр	12	40%	Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолын дагуу Музей-Номын Сангийн цогцолбор 2021-2023 онд нийт 14,533,0 тэрбум төгрөгөөр баригдах бөгөөд 2022 онд барилгын эхний үе шатны ажлыг “Бокон” ХХК гүйцэтгэсэн. Эхний үе шатны ажил буюу суурийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 1	100%

						давхарын угсралтын ажил дууссан. Тус ажлын гүйцэтгэлийн асуудлаар Соёлын яам, захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудын хамтарсан хурлыг 2022 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан.	
3.2.2	Орхон сумын Соёлын төвийн 2 давхар барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	285.0 сая ОНХС	Ажлын гүйцэтгэлээр	-	100%	Орхон сумын ОНХС-ийн 285,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус сумын Соёлын төвийн барилгын 2 дугаар давхрын 600 м.кв талбайн их засварыг “БДЗ ХХК” хийж гүйцэтгэн 2022 оны 08 дугаар сарын 31-нд ашиглалтад оруулж комисст хүлээлгэн өгөв.	100%
3.2.3	Шарын гол сумын Соёлын төвийн Орон нутаг судлах танхимыг шинээр байгуулах ажлыг эхлүүлнэ.	80.0 сая УТХО	Ажлын гүйцэтгэлээр	-	50%	Шарын гол сумын Соёлын төвийн дотор засварыг ОНТ-ийн 181,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Чонотдеволопмент” ХХК хийж гүйцэтгэн 11 дүгээр сарын 30-нд дуусган комисст хүлээлгэн өгөв. Улмаар сумын Соёлын төвийн орон нутаг судлах танхимыг улсын төсвийн 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр ажлыг эхлүүлсэн. Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой ажил түр зогссон байна.	Нэмэлтээр Соёлын төвийн дотор талыг бүрэн зассан. 100%
3.2.4	Орхон сумын Орон нутгийн судлах танхимыг тохижуулна.	8.0 сая ХХХО	Ажлын гүйцэтгэлээр	-	100%	“Сонгдо Хайрхан” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хийж өгөхөөр гэрээ байгуулсан. Танхимын зураг батлагдсан. Тохижилтын зардлыг 2023 орон нутгийн төсөвт суулгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	50%
3.2.5	Залуучууд театрын дууны тоног төхөөрөмж худалдан авна.	79,5 ОНТХО	Ажлын гүйцэтгэлээр	-	100%	Залуучууд театрт шаардлагатай байгаа дууны тоног төхөөрөмж худалдан авахаар 2022.09.07-ний өдөр нээлттэй тендер зарласан. Шалгарсан компани тоног төхөөрөмж нийлүүлэхийг хүлээж байна. Ондoo багтана.	100%

ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Зорилго 1.Үйлчилгээний стандартыг мөрдүүлэн, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн нэмэгдүүлнэ.

4.1	Зорилт 1. Эрэлтэд нийцсэн соёл, урлагийн үйлчилгээг үзүүлнэ.
-----	---

4.1.1	<p>Дархан хот байгуулагдсаны 61 жилийн ойн баяр, Ардын хувьсгалын баяр наадамд зориулсан урлаг, уран сайхны /Наадмын нээлтийн тоглолт, “Жаргалтай жарны дуулал” хүндэтгэлийн концерт, Үдшийн шоу цэнгүүн зэрэг/ арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.</p>	ОНТ	<p>Хэрэгжилтийн хувиар</p> <p>Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журмын 2.1.1-ийн хүрээнд</p>	-	100%	<p>“Жаргалтай жарны дуулал” хүндэтгэлийн концертыг Залуучууд театрын Ерөнхий найруулагч МУСТА, М.Цогт шинээр найруулан 2022.07.09-нд 1 удаа, 2022.10.15-нд 2 удаа, 2022.10.16-нд 1 удаа, 2022.10.17-нд 1 удаа нийт 5 удаа тоглож 3000 иргэдэд үнэ төлбөргүй толилууллаа.</p> <p>Дархан хотын 60, 61 жилийн ойн баяр наадмын “НЭЭЛТ, ХААЛТ”-ын тоглолтыг МУСТА, найруулагч Г.Саранчимэг 7 дугаар сарын 10, 11-нд шинээр найруулан толилуулсан. Аймгийн баяр наадмаар нийт 1000 гаруй үзэгчдэд хүргэсэн.</p> <p>- Дархан хот байгуулагдсны 60, 61 жилийн ойн баяр наадмын нээлтэд зориулсан Дрифтийн тэмцээнийг аймгийн ЗДТГ, Соёл, урлагийн газар, Монголын мэргэжлийн спорт автомашины холбоо хамтран зохион байгууллаа. Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгаас нийт 36 тамирчин оролцов. Цаашид дээрх тэмцээнийг уламжлал болгон зохион явуулж байхаар болсон.</p> <p>- СУГазар, Хүүхдийн номын ордон, МЗЭ-ийн Дархан салбар зөвлөл хамтран Дархан хотын 60, 61 жилийн ойн өдрийг угтан “Гал өд” яруу найргийн тэмцээнийг 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Зохион байгуулалт болон шилдэг шүлгийн түүвэр хэвлүүлэхэд зориулж орон нутгийн төсвөөс 4,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- “Дархан хот нэгэн жаранд” үзэсгэлэнг хотын өдрөөр толилуулав. Үзэсгэлэнд орон нутгийн төсвөөс 555.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>	100%
-------	---	-----	---	---	------	--	------

						<p>- “Дархан хотын хөшөө дурсгал - Миний дуранд” гэрэл зургийн уралдааныг 2022.10.16-ны өдөр дүгнэсэн. Тус уралдааныг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 2.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- “Бууж саатах Бурхантын хөндий” хотын аялалыг Дархан хотод шинээр суурьшин ирэгсэд болон нэгдүгээр курсын оюутнуудад зохион байгуулав.</p>	
4.1.2	Малчид, СӨББ, эрх нь хязгаарлагдсан иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны тоо	10 удаа 711 боть номоор	10 удаа 700 боть номоор	<p>- Салхит баг, Хонгор сум, Шарын гол сумын алслагдсан иргэд, ЕБС-ийн 370 хүнд номын сангийн үйлчилгээг хүргэж ажилласан. Мөн зөөврийн номын сангаар 7 хоног тутам “Од цогцолбор” сургуулийн 3-р ангийн нийт сурагчдыг хамруулсан. 1 удаа 30-40 боть номоор үйлчилж нийт 360 хүүхэд хамрагдсан.</p> <p>- Зөөврийн номын сангийн үйлчилгээг 6 цэцэрлэг, 16 сургууль, 2 их сургууль, 10 төрийн байгууллага, ШШГЕГ-ын хаалттай 435 дугаар анги нийт 41 удаа, /давхардсан тоогоор 2450 хүүхэд болон том/ 3132 боть ном хүргэсэн байна.</p> <p>- Нүүдлийн номын сангийн үйлчилгээг Зулзагын голын хүүхдийн зуслангийн амрагч хүүхдүүдэд 3 удаа, алслагдсан сургуулиудад нийт 5 удаа, нийт 8 удаа хүргэж, 559 шинэ уншигч бүртгэж, 2782 ирэгсдэд, 8976 ном олгож үйлчилсэн</p> <p>- “Номын богц”-ын үйлчилгээг ЕБС-ийн 8 сургуулийн 1-5 ангиудын 14 бүлэгт /22 удаа/ 986 боть номоор үйлчилсэн байна.</p>	100%
4.1.3	Хүүхэд багачууд руу чиглэсэн соёл, урлагийн олон талт	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан арга хэмжээний тоо,	-	20	Залуучууд театр нь дараах онцлог ажлуудыг хийв. Үүнд:	

	ажлуудыг зохион байгуулна.		хэрэгжилтийн хувиар		<p>- “Лануш” хүүхдийн жүжиг 16 удаа тоглож, 3830 хүүхдэд үйлчилсэн. 16 сая төгрөгийн орлого төвлөрүүлэв.</p> <p>- “Хараацай хэдгэнэ хоёр” хүүхэлдэйн жүжиг 6 дугаар сарын 1-нд 2 удаа үнэ төлбөргүй тоглогдож 800 хүүхдэд үзсэн.</p> <p>- “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийг шинээр найруулан тавьж 2022 оны 9 дугаар сарын 19-ны өдрөөс нийт 30 удаа тоглож 9419 хүүхэд багачуудад хүргэсэн.</p> <p>Найруулагчаар Залуучууд театрын жүжигчин Л.Хишигсүрэн ажилласан. Тус уран бүтээлд орон нутгийн төсвөөс 37.893.800 төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дэмжсэн.</p> <p>- “Үлгэрийн Ертөнц 2” кино контентыг найруулан 12 удаа тоглож хүүхэд багачуудад толилуулав.</p> <p>- 11 дүгээр сарын 07-ны өдөр ОИЦ сургуулийн ахлах ангийн 150 гаруй сурагчдыг хамруулан урлагийн 4 төрлийн мэргэжил сурталчлах ажлыг зохион байгууллаа.</p> <p>- Төв номын сантай хамтран Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны их сургуулийн оюутнуудад “Бидний бахархал” лекц, тоглолтыг зохион байгууллаа.</p> <p><u>Аймгийн Музей нь дараах ажлуудыг хийв.</u> Үүнд:</p> <p>- “Музейн макет бүтээх уралдаан” зарлаж шилдэг бүтээлийг шалгаруулж 300.000 төгрөгөөр шагнав.</p> <p>-Хэлний Бодлогын Үндэсний Салбар Зөвлөлийн Дархан салбартай хамтран “Мөнх оршихуй-III” бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулж багш, сурагчдын 42 бүтээлээр үзэсгэлэн гаргав.</p> <p>- “ДУА-ийн Хөгжлийн Бэрхшээлтэй Эцэг Эхчүүдийн Холбоо”-той хамтран 7 гэр бүлийн хүүхдүүдэд “Мандала” боловсролын хөтөлбөр, ээж нарт нь СББӨ-ийг өвлөн уламжлагч</p>	100%
--	----------------------------	--	---------------------	--	--	------

					<p>С.Одонцоо бий биелгээ зааж, өв соёлоо түгээв.</p> <p>-БТСГ-ын дэргэдэх Эцэг Эхийн Зөвлөлтэй хамтран тус байгууллагын албан хаагчдын 25 хүүхдэд “Дархан-Миний хот” Дархан хотын түүх, соёлын дурсгалтай танилцах аялалыг зохион байгуулав.</p> <p><u>Төв номын сангаас дараах ажлуудыг хийв.</u></p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 20 ангийн 658 сурагчийг хамруулан урилгат уншлага зохион байгуулсан. - 10 удаа 447 хүүхэд багачуудад, 6 удаа алслагдсан цэцэрлэгүүдэд сонгогдсон үлгэрүүдээр чанга уншлага хийв. - Найрамдал талбайд 2 удаа, 5, 6, 15-р баг, “Дархан-50” цогцолборт 2 удаа Зуны уншлага хийв. - Цэргийн штабтай хамтран аймгийн Засаг даргын нэрэмжит “Бид эх орны ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж эхний 10 байранд орсон сурагчдыг шагнав. ЕБС-ийн 70 гаруй багш, сурагчид оролцов. - “Би ээжийнхээ он цагийн үргэлжлэл” уралдаанд Орхон, Хонгор, Шарын гол сум, Дархан сумын ЕБС-ийн сурагчид, ШШГ хорих 435 дугаар анги, Улаанбаатар, Сэлэнгээс нийт 400 гаруй хүн оролцов. - 2022 онд Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн шагналаар ЕБС-ийн 11 анги хамт олон, 18 сурагчийг шагнав. - Соёл, урлагийн газар, БШУГ хамтран Хүүхдийн гар урлалын бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулав. /300 хүн хамрагдсан/ - Жаран нэгэн сурагчийн бийрийн бичвэрийн үзүүлэх тоглолтыг зохион байгуулж
--	--	--	--	--	---

						<p>Дархан хотын сүлд дуу “Хамгийн сайхан хот”-ын үгийг өөр өөрийн өнгө аясаар сэтгэмжлэн бичүүллээ. Мөн үеэр багш, сурагчдад бийрэн бичлэгийн хэрэглэгдэхүүн хүлээлгэн өгөв.</p> <p>- СУГ, Монгол II загварын агентлаг хамтран “Super fashion-2022” төвийн бүсийн Шилдэг шинэ залуу модел, Шилдэг фото модел шалгаруулах 3 дахь удаагийн уралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулав. II шатанд шилдэг 55 хүүхэд оролцов.</p>	
4.1.4	Музейн үзмэрийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон иргэдэд цахим болон танхимын хэлбэрүүдээр үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Музейн үйлчилгээнд хамрагдсан иргэд, хүүхдийн хувь	50	85%	<p>2022 онд оюутан залуус, хүүхэд багачуудад зориулсан 5 төрлийн боловсролын хөтөлбөрийг 75 удаа зохион байгуулж 2747 хүүхэд хамрагдаж 2,747,000 төгрөгийг төлөврүүлсэн. Үүнээс эхний хагас жилд 34 боловсролын ажилд ЕБС-ийн 780 сурагчийг хамруулсан.</p> <p>Сан хөмрөгт хадгалагдаж буй алтан ургийн 37 хаадын хөрөг үзмэрүүдээр үзэсгэлэн гаргаж, “Монголын Их Хаад” шинэ боловсролын хөтөлбөр хэрэгжүүллээ.</p> <p>Соёл урлагийн ажилтны өдрөөр:</p> <p>- Хонгор сумын ЕБС-ийн сурагчдад “Хорол, Үйчүүр” боловсролын хөтөлбөрийг сурталчилан таниулсан.</p> <p>- Дархан суманд “Музейн үзмэрийн дээжис” гэрэл зургийн үзэсгэлэн, “Мандала” боловсролын хөтөлбөрийг зохион байгууллаа. Уг хөтөлбөрт 100 гаруй хүүхдүүдийг хамруулсан.</p> <p>- Хотын ойн өдрөөр буюу 10 дугаар сарын 16-18-нд музей үнэ төлбөргүй үйлчилж 983 иргэд хамрагдав.</p> <p>- “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд “Дархан-Уул аймгийн урлагийн бүтээлүүд”</p>	100%

						<p>үзэсгэлэн, сурагчдад зориулсан Боловсролын хөтөлбөр, иргэдэд зориулсан “Дархантай танилцах хотын аялалын хүрээнд 829 сурагч, нийт 1244 үзэгч хамруулан ажиллалаа.</p> <p>- Хонгор сумын Соёлын төвийн орон нутаг судлах танхим нь нийт 54 хүүхдэд орон нутаг, байгаль, түүхийн талаар мэдлэг олгож үйлчилсэн.</p>	
4.1.5	Салбарын байгууллагуудад зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Зөвлөн тусалсан байгууллагын тоо	-	7	<p>- Соёл, урлагийн газраас Музей, 3 сумын соёлын төвүүдэд Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн улсын тооллого, Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг хэрхэн зохион байгуулах болон бусад соёлын ажлуудаар тус бүр 2 удаа зөвлөн туслав.</p> <p>- Аймгийн Төв номын сангаас их дээд сургууль, ЕБС, Хонгор, Орхон, Шарын гол сумдын нийтийн номын сангуудаар очиж нийт 28 байгууллагын 33 номын санчид зөвлөн туслав.</p> <p>- Соёл, урлагийн газраас Долоо хоног бүрийн Лхагва гарагт соёлын байгууллагуудын удирдлагуудтай танхим болон цахим хэлбэрээр 7 удаа хуралдаж Соёлын яам, ЗГХА-Соёл, урлагийн газар, аймгийн Засаг даргын шуурхай хурлаас гарсан цаг үеийн мэдээллийг тогтмол мэдээлж, зөвлөмж өгч ажилласан.</p>	100%
ТАВ. ХУУЛИАР ОЛГОГДСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ							
5.1. Бүх шатны төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй хүргэнэ.							
5.1.1	Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	20	Соёл, урлагийн чиглэлээр тусгагдсан 2 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны хэрэгжилт 75 хувьтай.	100%

	төлөвлөгөөний 2022 оны зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллана.						
5.1.2	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	20	Соёл, урлагийн байгууллагын хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн 6 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны хэрэгжилт 91 хувьтай.	100%
5.1.3	2022 оны Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	100%	Аймгийн ИТХ-ын 10 дугаар тогтоолын дагуу 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө 1.6-д заасан Соёл, урлагийн байгууллагын хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн 2 арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэн тайланг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	100%
5.1.4	Ёс зүйг дээдлэх зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагаа	Ёс зүйн зөрчил гаргахгүй ажилласан эсэх	-	100%	<p>- Соёл, урлагийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн тайланг авч нэгтгэн 2022 оны 09 дүгээр сарын 20-нд Соёлын яам болон аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хэлтэст албан бичиг, хавсралтын хамт хүргүүлсэн.</p> <p>- 2022 оны 09 дүгээр сарын 26-29-нд Дархан-Уул аймагт ажилласан Авлигатай тэмцэх газрын хяналт, шалгалтын ажлын хэсэг нь Соёл, урлагийн газрын албан хаагчдыг томилсон Б тушаалыг хянасан.</p> <p>- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан тухай тайланг 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Соёлын яамны цахим info@moc.gov.mn хаягаар хүргүүлээ.</p>	100%

						<p>- 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/21 дугаартай “Ёс зүйн зөвлөл байгуулах тухай” тушаалыг газрын даргаар батлуулсан. Тус зөвлөл нь албан хаагчдын ёс зүйтэй холбоотой аливаа асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна.</p> <p>- 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр соёлын байгууллагуудын нийт албан хаагчид Ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн тангаргыг сэргээн уншиж тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.</p> <p>Тайлант онд Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.</p>	
5.1.5	Хүүхэд хамгааллын жилийн ажлын зорилтын хүрээнд олон талт ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоо	-	5	<p>Тус аймаг нь 2022 оныг Хүүхэд хамгааллын жил болгон зарласан. 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/13 дугаар “Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай” тушаалыг Соёл, урлагийн газрын даргаар батлуулсан. Мөн Соёлын байгууллагууд тус бүр “Эцэг эхийн зөвлөл” байгуулж “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:</p> <p>1.Хүүхдийн соёлын орчныг нэмэгдүүлэх чиглэлээр:</p> <p>2.Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр: 3.Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг зарчмын хүрээнд:</p> <p>4.Үндэсний өв соёл шингэсэн цахим контентуудыг бүтээхэд бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд Соёлын 7 байгууллага тус бүр 4 арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Биелэлтийн тайланг нэгтгэж 2022 оны 10 дугаар сарын 25-нд ЗГХА Соёл, урлагийн газарт хүргүүлэв.</p> <p>Тайланг хавсаргаав.</p>	100%

						<ul style="list-style-type: none"> - “Нэгдүгээрт хүүхэд” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж хөшиг нээгдэх бүрд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүргийг сануулсан “Хүүхдээ сонсоё-Хүлээцтэй байцгаая” уриалгыг хэлж хэвшсэн. - Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр постер, уриалгыг хийж СУГ-ын цахим хуудсанд байршуулж олон нийтэд уриалсан. - Музейн Эцэг Эхийн Зөвлөлөөс 31 дүгээр цэцэрлэгийн эмч П.Алтанзултай хамтран албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Ахуйн хүрээн дэх осол гэмтэл, тэдгээрийн үед авах арга хэмжээ” сургалтыг туршилтад суурилан зохион байгууллаа. - Соёл, урлагийн газар нь аймгийн Засаг даргын 3-10/1500 тоот үүрэг даалгаврын дагуу бага насны хүүхдүүдтэй эцэг эхчүүдэд хүүхдээ цэцэрлэг, сургуульд өгч авах нөхцөлөөр хангах, 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн “Мэндэлсэн өдөр”-өөр тухайн өдрийн цалинтай чөлөө олгож дэмжин ажилласан. Хэрэгжилтийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. 	
5.1.6	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	100%	<ul style="list-style-type: none"> - Соёл, урлагийн газар нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж мэдээ тайланг цаг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна. - Хяналт-шинжилгээ үнэлгээний цахим сан, гүйцэтгэлийн удирдлагын цахим санг ашиглах дадлагажих ажлууд хийгдэж байна. - Дархан-Уул аймгийн соёлын салбарын харьяа байгууллагуудын 1, 2, 3 дугаар 	100%

						улирлын статистик мэдээнд харьцуулалт, дүн шинжилгээг хийж байгууллага тус бүрээр нь 1, 2, 3-р улирлын бүх тоон үзүүлэлтийг задалж график харьцуулалт хийн, дүн шинжилгээ хийж удирдлагад танилцуулж ажилласан.	
5.1.7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	100%	<p>XIII.5.2. Төрийн болон <u>орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгааг хамтран баталж мөрдүүлэх</u>, харуул хамгаалалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх заалтыг хасуулах санал хүргүүлсэн. Учир нь: Аймгийн Музей нь харуул хамгаалалтын ажилтан байхгүй учир дохиолол, хамгаалалтын үйлчилгээг Дархан секьюрити ХК-тай гэрээ байгуулан хамтран ажилладаг.</p> <p>XIII.5.4. Харьяалах нутаг дэвсгэр дэх <u>соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг</u> сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүрээнд Түүх, Соёлын Хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 5 судар бичигт модон шогол хийлгэсэн. Орон нутгийн төсвийн 3.500.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 ширхэг уран баримлыг сэргээн засварлах ажил хийгдэж, үзмэрийн хадгалалт хамгаалалт сайжирсан.</p> <p>- Соёлын тухай хуулийн 30 дугаар зүйл. Соёлын орчин, орон зайг хөгжүүлэх 30.1, 30.2-т заасны дагуу Соёлын орон зай бий болгох санаачилгыг аймгийн Засаг даргад болон Сангийн сайдад уламжилж 500 сая төгрөгийн дэмжлэг авах боломж бүрдсэн. Соёлын орон зай бүрдүүдэх ажлын хүрээнд аймгийн СУГазар, Зураач, урчуудын холбооноос 2 төрлийн байршилд зураг хийж аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэст</p>	100%

						<p>танилцуулсан. Ирэх онд шийдвэрлүүлэхээр болов.</p> <p>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигт тусгагдсан хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх, согтууруулах ундааны хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах чиглэлээр архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх “НАМАЙГ АЛГАС” ухуулга нөлөөллийн аянд 2022 оны 11 дүгээр сарын 30-аас 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд аймгийн Соёл, урлагийн газар, соёлын байгууллагууд нэгдсэн.</p> <p>- “Нандин бүхнээ хамгаалъя – өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” уриатай үндэсний хэмжээний Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд аймгийн Соёл, урлагийн газар, соёлын байгууллагууд нэгдсэн. Соёл, урлагийн байгууллагын 20 албан хаагчаас Жендерийн асуулгын үнэлгээний судалгаа авч Соёлын яаманд цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн.</p>	
5.1.8	<p>Сайдтай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтэд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг цаг хугацаанд нь аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллагад хүргүүлэх,</p>	Үйл ажиллагаа	Тайлан ирүүлсэн байна	0	1	<p>Монгол Улсын Засгийн газрын гишүүн Соёлын сайд, Аймгийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу 5 чиглэл, 42 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хагас жилээр гэрээний үүргийн биелэлтийг 83,33 хувьтай үнэлүүлсэн.</p> <p>Жилийн эцсийн биелэлтийг гарган ажиллаж байна.</p>	100%

	удаашралтай байгаа ажлуудад дүн шинжилгээ хийж, ажил эрчимжүүлэх талаар санаачилгатай ажиллана.						
5.1.9	Удирдах ажилтны шуурхай хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	100%	Удирдах ажилтны шуурхай хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд: - Иргэдийн авто зогсоол, 00 асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Соёлын байгууллагаар тэр дундаа Залуучууд театраар үйлчлүүлж буй иргэдэд авто зогсоолын талбайг чөлөөлж ажиллалаа. Нийтийн 00-ыг хэвийн ажиллуулж байна. - Дархан-Уул аймаг авилга, ашиг сонирхлоос ангид байх тэргүүний аймаг болох уриалгын хүрээнд соёлын байгууллагын ажилтнуудад авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар мэдээлэл хийсэн. - 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3-10/1500 дугаар албан тоотын дагуу СӨБ-ын болон ЕБС-ийн насны хүүхдүүдээ хүргэж өгөх, авах нөхцөлөөр 4 ажилтныг хангасан. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлийн 6.9 дэхь заалтад оруулж батлав. Тус үүрэг даалгаврын биелэлтийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 02-нд Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэв. - Байгууллагын нийт албан хаагчдыг Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд яаралтай хамруулах гэсэн үүргийн дагуу Соёл, урлагийн газрын 6 албан хаагч эмчийн үзлэг, оношилгоонд хамрагдлаа. - 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 2-10/1045 дугаар албан тоотын дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд авч буй арга хэмжээний талаарх хэрэгжилтийн тайланг 7	100%

						<p>хоног бүрийн 5 дахь өдөр Аймгийн Шуурхай штабт нийт 7 удаа хүргүүлсэн.</p> <p>- “Open mic” арга хэмжээг таслахгүйгээр үргэлжлүүлэх чиглэлийн дагуу аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Залуучууд театрт хамтран тус арга хэмжээг Дархан-Уул аймгийн 50 цогцолбор, Хүүхэд хөгжлийн ордон, Хуримын ордон гадаа талбай зэрэг газруудад нийт 25 удаа зохион байгуулагдаж 750 гаруй иргэн оролцож 500 гаруй хүнд хүргэлээ.</p>	
5.1.10	Аймгийн Засаг даргын 2022 оны захирамж, албан даалгаврыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	100%	<p>2022 оны 12 дугаар сарын байдлаар дараах захирамжуудыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:</p> <p>- 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/130 дугаар тоот Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Дархан хот байгуулагдсаны 60, 61 жилийн ой, Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг хангуулах, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулах тухай:</p> <p>- 2022 оны 08 дугаар сарын 04-ний 01-А/223 дугаар тоот Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн тооллого хийх журмын 2.1, 4.2, Тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай:</p> <p>- 2022 оны 10 дугаар сарын 28-ны 01-А/299 дугаар тоот Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Соёлын биет бус өвийн үзлэг, судалгааг Аймгийн хэмжээнд зохион байгуулах салбар ажлын хэсэг байгуулах тухай</p>	100%
5.1.11	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, соёлын байгууллагууд байгууллагынхаа эргэн тойронд болон	Үйл ажиллагаа	Арга хэмжээ зохион байгуулсан эсэх	0	-	<p>- Хаврын мод тарих үйл ажиллагаагаар аймгийн Музей 6 ш хайлаас, Хүүхдийн номын ордон 15 ш хайлаас, Төв номын сан 15 ш хайлаас, Залуучууд театр Улиас мод 18 ш, Агч мод 22 ш, Голт бор 233 ш, Таримал хайлаас 500 ш, Нарс 14-ийг тус тус тарьсан.</p>	100%

	нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж, арчилж ургуулна.					<p>- Намрын мод тарих үйл ажиллагаанд соёл, урлагийн салбарын 5 байгууллагын нийт 86 ажилтан нэгдэж модны мөнгө болох 2 418 922 төгрөгийг орон нутагт хандивласан.</p> <p>- Шарын гол сумын соёлын төв нь сумынхаа "Мини цогцолбор"-ын талбайд 42 ш хайлаас мод тарьсан.</p> <p>- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Шидэт модны үр" хүүхдийн жүжгийг шинээр найруулан тавьж 2022 оны 9 дугаар сарын 19-ны өдрөөс нийт 30 удаа тоглож 9419 хүүхэд багачуудад хүргэсэн.</p>	
5.1.12	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, тоног төхөөрөмж, бараа материалыг зориулалтын дагуу ашиглаж буйд хяналт тавих, орон нутгийн өмчид бүртгэлжүүлнэ.	Үйл ажиллагаа	Орон нутгийн өмчид бүртгүүлсэн байна	0	1	<p>Тайлант оны жилийн эцсийн байдлаар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын Соёлын төвийн барилгын 2 дугаар давхрын их засварын ажлыг 285,5 сая төгрөгөөр, Шарын гол сумын Соёлын төвийн дотор засварыг 181,7 сая төгрөгөөр хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авч бүртгэлжүүлсэн.</p> <p>Мөн ОНТХО-аар Залуучууд театрт дууны тоног төхөөрөмжийг 79,5 сая төгрөгөөр, Шарын гол сумын Соёлын төвд 34,8 сая төгрөгөөр Лэд дэлгэц, 53,0 сая төгрөгөөр гадна фасадын ажил, 45,0 сая төгрөгөөр дээврийн засварын ажлыг тус тус хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгч, орон нутгийн өмчид бүртгэлжүүлсэн.</p>	100%
5.1.13	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх их засвар, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын ажлын саналыг хүргүүлнэ.	Үйл ажиллагаа	Бэлтгэл хангагдсан байна	0	1	<p>Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Соёлын салбарын 7 байгууллагын 2023 онд шаардлагатай байгаа их засвар тоног төхөөрөмжийн судалгааг авч нэгтгэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,4 тэрбум төгрөгийн саналыг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар албан тоотоор, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар</p>	100%

						хийгдэх 301,5 сая төгрөгийн саналыг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 141 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөл, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.	
5.1.14	Соёл, урлагийн газрын албан хэргийг хөтлөж, байгууллага иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж ажиллана.	Үйл ажиллагаа	Албан хэрэг хөтлөлтийн стандарт, Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ	-	100%	Тус газар нь албан хэрэг хөтлөлтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол, стандартын стандартын дагуу хөтлөж байна. Үүнд: -Ирсэн, явсан бичгийн бүртгэл, Өргөдөл, гомдлын бүртгэл, Хэвлэмэл хуудасны зарцуулалтын бүртгэл, Газрын А/Б тушаалын бүртгэл, хурлын тэмдэглэлийн бүртгэл, бичиг, тараах бүртгэл, албан хаагчдын цагийн бүртгэлийг тус тус хийж байна. Ашиглаж буй бүх төрлийн хэвлэмэл хуудсыг дугаарлахад хэрэглэх “Хэвлэмэл хуудасны индекс”-ийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/03 дугаар тушаалыг хавсралтын дагуу газрын даргаар батлуулсан. Байгууллагад 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 172 албан бичиг ирсэн. Үүнээс хариутай албан бичиг 32, явуулсан албан бичиг 152 байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гаргаж хэвшсэн. Тайлант хугацаанд байгууллага, иргэдээс өргөдөл гомдол ирээгүй. Эхний хагас жилийн архивлалт хийгдсэн.	100%
5.1.15	Соёлын байгууллагуудын санхүүгийн тайланг олон улсын стандартад	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар	-	1	- Соёл, урлагийн газрын хагас жилийн санхүүгийн тайлан, харъяа 7 байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг 8 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд Соёлын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргэн ажилласан.	100%

	нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.					<p>- Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу 2022 оны 3 дугаар улирлын тайланг Э-Тайлан системд нэгтгэсэн. 2022 оны жилийн эцсийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн хугацаанд нь гаргаж аудитын дүгнэлт гаргуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>- Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь хийж ил тодын самбар shilendans.gov.mn цахим сайтад байршуулсан.</p> <p>- Сангийн яам, Дэлхийн Банк хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь Засаглалыг Бэхжүүлэх” төслийн хүрээнд хөгжүүлж буй Шилэн дансны шинэчилсэн нэгдсэн цахим хуудсанд хэрэглэгчийн эрхийг бүртгүүлж мэдээллийг оруулан ажиллаж байна.</p>	
5.1.16	Байгууллагын албан хаагчдын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллана.	Үйл ажиллагаа	Хэрэгжилт хувиар ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тоот тушаал	-	Гүйцэтгэл	<p>Соёл, урлагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хагас жилээр тайлагнав. Газрын албан хаагчид, 3, 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган дүгнүүлж ажиллав.</p> <p>Мөн 2022.12.07-ны өдөр аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэлэлцэв. Тус хуралд Залуучууд театр, Музей, Номын сан, Хүүхдийн номын ордон, Сумын соёлын төвийн дарга нар оролцож үйл ажиллагаагаа танилцууллаа.</p>	100%

Төлөвлөгөөний биелэлтийг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
(албан тушаал)



Б.АЗЖАРГАЛ

/...../
(огноо)

Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ,

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



(албан тушаал)

/...../

(огноо)

Тэмдэг

**СОЁЛ УРЛАГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2022.12.28

Дархан-Уул аймаг

д/д	Үнэлгээ		Бүгд	Бодлогын баримт бичиг	Хуулиар олгосон чиг үүрэг хэрэгжүүлэх		Төрийн үйлчилгээний чанар хүртээмж
	Чиглэл				Тусгайлан олгосон чиг үүрэг	Нийтлэг чиг үүрэг	
1	Зорилтын тоо		9	2	2	4	1
2	Арга хэмжээний тоо		56	9	11	31	5
3	Үнэлгээ, үүнээс	100%	46	5	10	27	4
		90.00%	9	4	0	4	1
		70.00%	0	0	0	0	0
		50.00%	1	0	1	0	0
		30.00%	0	0	0	0	0
Ерөнхий үнэлгээ, хувь			97.1% буюу 4.85 оноо	95.5% буюу 4.77 оноо	95.4% буюу 4.77 оноо	98.7% буюу 4.93 оноо	98% буюу 4.9 оноо

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

П.БАЯРСАЙХАН

